



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Улсын Их Хурлын саналын дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

## ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙЖЭЭ

Бүс, орон нутгийн хөгжилд зориулж олгосон  
хөрөнгийн зарцуулалт, үр дүн, орон нутгийн  
оролцоо

# Агуулга

## Тайланг бэлтгэсэн:

### ҮАГ-ын Нэгдүгээр газар

Газрын захирал

Д.Ганбилэгэ

Аудитын менежер

Ж.Батсайхан

Ахлах аудитор

Л.Одгэрэл

Аудитор

А.Сүхбаатар

Д.Гандолгор

Шинжээч

Ц.Эрдэнэчулуун

П.Цэнгүүн

Хянасан

Аудитын менежер

Ж.Батсайхан

2007 оны 10 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын  
Веб сайтаас үзнэ үү:

[www.mnao.pmis.gov.mn](http://www.mnao.pmis.gov.mn)

Аудитын тайлантай  
холбоотой асуудлаар нэмж  
тодруулах, асууж лавлах зүйл  
байвал 261628 дугаарын утас,  
323266 дугаарын факсаар  
харилцана уу.

### ХАЯГ:

Үндэсний аудитын газар  
Засгийн газрын 4 дүгээр байр,  
Бага тойруу-6, Улаанбаатар-46  
Монгол Улс

Товчилсон үгсийн жагсаалт . . . . . 2

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй . . 3

## Бүлэг 1

### Зарим төсөл, арга хэмжээний төлөвлөлт орон нутгийн ажилтай уялдаагүй байна

I.1 Төсөл, арга хэмжээг орон нутгийн төр, захиргааны байгууллага иргэдийн саналыг үндэслэн төлөвлөжээ.....4

I.2 Төлөвлөгөөнд зохицуулалт хийжээ.....5

## Бүлэг 2

### Бэлтгэсэн хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй байна.

II.1 Зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг зохих журмын дагуу санхүүжүүлээгүй үлдэгдлийг төсөвт буцааж төвлөрүүлээгүй байна .....6

II.2 Зарим төсөл, арга хэмжээг гэрээт хугацаанд хийгээгүй, шаардлага хангасан хөрөнгө нийлүүлээгүй байна.....8

II.3 Төсөл, арга хэмжээний үр дүнд бэлтгэсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй байна .....11

II.4 Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг зохих журмын дагуу сонгоогүй байна.....11

II.5 “Орон нутгийг мэдээлэлжүүлэх” төслийн ажил дуусаагүй, улсын комисс хүлээж аваагүй байна.....12

### **Бүлэг 3**

---

#### **Ажлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байжээ.**

III.1 Орон нутгийн төр, захиргааны байгууллагаас хөрөнгийн зарцуулалт, ажлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байна.....15

III.2 Зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд орон нутгийн иргэдийн оролцоо хангалтгүй байсан байна.....15

**ДҮГНЭЛТ... .. 17**

**Холбогдох байгууллагын санал ... .. 18**

**ЗӨВЛӨМЖ... .. 20**

**Хавсралт А,Б,В,Г,Д,Е,Ж,З ... .. 22**

# Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
СЭЗЯ	Санхүү, эдийн засгийн яам (хуучин нэрээр)
ҮТЕГ	Үндэсний татварын ерөнхий газар
УМХГ	Улсын мэргэжлийн хяналтын газар
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
СБД	Сүхбаатар дүүрэг
БГД	Баянгол дүүрэг
СХД	Сонгино хайрхан дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг
ХУД	Хан - Уул дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
УЦС	Усан цахилгаан станц
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БХБТГ	Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газар
ТББ	Төрийн бус байгууллага
ЗАА	Захирагчийн ажлын алба
НААҮГ	Нийтийн аж ахуй, үйлчилгээний газар

## **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**

Аудитыг УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны санал, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2007 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

“Бүс, орон нутгийн хөгжилд зориулж 2006 онд төсвөөс олгосон 7,6 тэрбум төгрөгийн зарцуулалт, үр дүн, орон нутгийн оролцоо” гэсэн асуудлаар аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитаар Сангийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтэс, Төрийн сангийн газар, Шадар сайдын ажлын алба, аймаг, нийслэлийн Төрийн сангийн газраас гаргасан судалгаа, тайлан, гүйцэтгэлийн баримтууд, төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагын 2006 оны санхүүгийн болон татварын тайлан, мэдээ, холбогдох санхүүгийн баримтуудыг шалгав.

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн шалгалтын журам, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгосны зэрэгцээ холбогдох албаны мэргэжилтэн, иргэдтэй ярилцлага хийх, судалгаа, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

# Бүлэг 1

## **Зарим төсөл, арга хэмжээний төлөвлөлт орон нутгийн ажилтай уялдаагүй байна**

### **1.1 Төсөл, арга хэмжээг орон нутгийн төр, захиргааны байгууллага иргэдийн саналыг үндэслэн төлөвлөжээ**

1.1 Улсын төсвийн хөрөнгөөр 2006 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт батлах тухай Засгийн газрын 2006 оны 19 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар “Улсын төсвийн хөрөнгөөр бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ”-ний жагсаалтыг баталсан байна.

1.2 Энэ жагсаалтаар 175 төсөл, арга хэмжээнд 7,6 тэрбум төгрөг төлөвлөж, энэ арга хэмжээг нийслэл, аймаг, сум бүрт хэрэгжүүлэх шийдвэр гарчээ. /Хавсралт А/

1.3 Дээрх төсөл, арга хэмжээнд зарцуулах 7,6 тэрбум төгрөгийг Шадар сайдын төсвийн багцад оруулан баталж, санхүүжилт, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг түүнд даалгасан байна.

1.4 Бүс, орон нутгийн хөгжилд зориулж олгосон хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө аймаг, орон нутгийн мэргэшсэн төсөвчид төсөл, арга хэмжээний төсвийг баталгаажуулж, аймгийн хөрөнгө оруулалт, захиалагчийн албаар дамжуулан аймгийн ЗДТГ нэгтгэж, ИТХ-аар төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталсан байна.

1.5 УИХ-ын гишүүдийн тойрогтоо хийх ажил, мөрийн хөтөлбөрийг орон нутгийн засаг захиргаа, иргэдийн санал хүсэлттэй уялдуулан уг төсөл, арга хэмжээний саналыг Шадар сайдын ажлын албаны Бүсчилсэн хөгжлийн үндэсний хорооны ажлын алба хянаж нэгтгэсэн байна.

1.6 Гэвч төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хөрөнгийн хуваарилалт зарим аймаг, орон нутгийн хувьд тэдний хэрэгцээ шаардлагыг харгалзаж үзээгүй, тухайн орон нутгийн бодлого шийдвэртэй нийцээгүй байна. Тухайлбал,

- Хэнтий аймагт хэрэгжүүлэх 6 төсөл, арга хэмжээ орон нутгийн төрийн байгууллагын ажлын төлөвлөгөөтэй уялдаагүй байна.

Хэнтий аймгийн 2006 оны бараа , ажил, үйлчилгээ худалдан авалтын төлөвлөгөөнд Жаргалтхаан сумын соёл, спортын төвийн барилгыг засварлах, Баянмөнх, Жаргалтхаан, Өмнөдэлгэр зэрэг 8 сумыг хөгжмийн тоног төхөөрөмжөөр хангах, Нэгдсэн эмнэлэгт тоног төхөөрөмж авах, Уламжлалт анагаах ухааны төвд тоног төхөөрөмж нийлүүлэх, Мөрөн суманд Цахилгаан дамжуулах шугам барих, соёлын төвийн барилгыг засварлах ажлууд тусгагдаагүй байна.

- Ховд аймгийн Буянт голын ус хуваарилах байгууламж ашиглалтад ороогүй, уг байгууламжийг ногоочид, зарим иргэд үр ашиггүй гэж тооцжээ. Мөст суманд Манхан сумаас өндөр хүчдэлийн шугам сүлжээ барихаар шийдвэрлэсэн атал суманд усан цахилгаан станц барина гэсэн нь байна.

## **1.2 Төлөвлөгөөнд зохицуулалт хийжээ**

1.7 Засгийн газрын 2006 оны 19 дүгээр тогтоолын 3 дугаар заалт, УИХ-ын гишүүд, аймгийн Засаг дарга нарын санал, хүсэлтийг үндэслэн 2006 оны 6 дугаар сараас 12 дугаар сарын хооронд Шадар сайд, Сангийн сайдын 9 удаагийн хамтарсан тушаалаар төсөл, арга хэмжээний батлагдсан дүнд багтаан зохицуулалт хийсэн байна. Үүнд:

д/д	огноо	Тушаалын дугаар	Дүн /сая төгрөг/	Зохицуулсан төсөл, арга хэмжээний тоо	
				батлагдсан	зохицуулсан
1	2007.06.02	51/173	432,7	5	8
2	2007.07.05	62/217	1942,8	29	29
3	2007.07.27	74/242	375,0	9	24
4	2007.09.01	77/279	194,28	5	4
5	2007.09.01	78/280	313,7	6	11
6	2007.11.06	108/350	194,28	2	5
7	2007.12.14	119/409	399,82	6	15
8	2007.12.18	126/416	100,0	1	5
9	2007.12.26	127/442	19,7	1	1
	Нийт дүн		3972,28	64	102

1.8 Зохицуулалт хийгдсэн төсөл, арга хэмжээний дийлэнх хэрэгжсэн байна.

1.9 Гэвч Шадар сайд, Сангийн сайдын 2006 оны 74/242 дугаар тушаалаар Хэнтий аймгийн Бэрх тосгоны цэцэрлэгийн засварын ажилд зориулж батлагдсан 49,0 сая төгрөгөөс 24.0 сая төгрөгийг уг цэцэрлэгийн засварт, үлдсэнийг Баянхутаг, Норовлин сумын сургуулийн барилгын засвар болон Бэрх тосгонд ундны ус, хог тээврийн автомашин авахад зарцуулахаар зохицуулалт хийсэн боловч Бэрх тосгоны цэцэрлэгийн засварт уг хөрөнгө зарцуулагдсан байсан учир нэмж төлөвлөсөн ажлууд биелэгдэх боломжгүй болжээ.

1.10 Шадар сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар Нийслэлд хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээний зориулалтыг өөрчилж, тавилга, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл бэлтгэхээр зохицуулахдаа төсөл, арга хэмжээний ач холбогдлыг үнэлж тооцсонгүй. Тухайлбал, 2006 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн Шадар сайд, Сангийн сайдын 62/217 дугаар тушаалаар “ Сонгуулийн 72 дугаар тойрогт “ 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт орших “Хүчит шонхор” захаас Баянхошууны засмал зам хүртэлх 2,1 км шороон замыг сайжруулах” –д зарцуулах 97,1 сая төгрөгийг 2006 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 119/409 дүгээр тушаалаар Чингэлтэй дүүргийн 7,8,9,10,11,12 дугаар хороонд тавилга, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж авахаар оны эцэст зохицуулалт хийжээ.

## **Бүлэг 2** *данс бүртгэлд бүрэн тусгаагүй байна* **Бэлтгэсэн хөрөнгийг**

### ***II.1 Зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг зохих журмын дагуу санхүүжүүлээгүй, үлдэгдлийг төсөвт буцааж төвлөрүүлээгүй байна***

2.1 Санхүү, эдийн засгийн сайдын /хуучин нэрээр/ 2001 оны 174 дүгээр тушаалаар батлагдсан “ Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, угсрагдахгүй тоног төхөөрөмж, их засварын ажлыг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын 3.2-т “Санхүү, эдийн засгийн яам төвлөрсөн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ, зам, барилга байгууламж, тоног, төхөөрөмж, их засварын ажлыг батлагдсан хөрөнгө, жагсаалтын дагуу хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын баримт, материалыг<sup>1</sup> үндэслэн санхүүжүүлнэ” гэж заасны дагуу Сангийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтэс 7451,0 сая төгрөгийн санхүүжилтийн эрх нээж 7436,8 сая төгрөгийг Шадар сайдын төсвийн харилцах дансанд шилжүүлсэн байна.

2.2 Харин Сангийн яам Хэнтий аймгийн Өндөрхаан сумын Нэгдсэн эмнэлгийн Сэхээн амьдруулах тасагт нийлүүлэх 14,2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн санхүүжилтийг “Залуус сан” байгууллагад шууд шилжүүлсэн байна.

2.3 Сангийн яамнаас бүс, орон нутгийн хөгжилд зориулж аймаг, нийслэлийн төрийн сангийн газарт 7451,0 сая төгрөгийн санхүүжилт хийжээ. /Хавсралт А,Г/


2.4 Төвийн бүсийн 18 төсөл, арга хэмжээнд 986,4 сая, Баруун бүсийн 25 төсөл арга хэмжээнд 874,9 сая, Зүүн бүсийн 12 төсөл арга хэмжээнд 507,4 сая, Хангайн бүсийн 19 төсөл арга хэмжээнд 1140,6 сая, Улаанбаатар бүсийн 64 төсөл арга хэмжээнд 1646,2 сая, орон нутгийг мэдээлэлжүүлэх төсөлд 2099,6 сая, нийт 138 төсөл, арга хэмжээнд 7255,0 сая төгрөгийг гүйцэтгэгчид олгосон байна. /Хавсралт А, Б, В, Г/

2.5 Дээрх хөрөнгийн зарцуулалтыг бүтцийн хувьд авч үзвэл дараахь байдалтай байна.

<sup>1</sup> Журмаар баримт материалд батлагдсан зураг, төсөл; тендерийн хорооны тогтоол буюу зөвлөмж; захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан ажил үүрэг гүйцэтгэх гэрээ; барилга угсралт, засварын ажил гүйцэтгэх график; санхүүжилтийн сар, улирлын хуваарь; эргэж төлөгдөх нөхцлөөр олгох зээлийн гэрээ; захиалагчаар баталгаажуулсан барилга байгууламжийн болон засварын ажлын гүйцэтгэл, ашиглалтад хүлээн авсан акт; эрх бүхий байгууллагын батлан гаргасан шийдвэр, барилга, байгууламж, засварын ажлын норм, нормативууд багтдаг байна.



**Төсөл арга хэмжээний нийт хөрөнгийн зарцуулалт**



2.6 Сангийн яам нийт санхүүжилтийн 43,0 хувь буюу 3,201.6 сая төгрөгийг 12 дугаар сард, түүний 34,1 хувь буюу 2,542.0 сая төгрөгийг 12 дугаар сарын 20-ноос хойш санхүүжүүлсэн байна.

Бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байдал

сарууд	Үнийн дүн / сая. төг/	Нийт санхүүжилтэд эзлэх хувь
6	76,1	1,0
7	276,9	3,4
8	839,8	11,3
9	556,3	7,5
10	1,107,0	14,8
11	1,417,3	19,0
12	3,177,6	43,0
Дүн	7451,0	100,0

2.7 Сангийн яам зохих баримтыг үндэслэн санхүүжилтийн эрхийг нээж санхүүжүүлсэн боловч тендерийг оройтуулж зарласан, төсөл, арга хэмжээнд зохицуулалт хийсэн, орон нутаг ажлын гүйцэтгэлийн баримтыг хугацаа алдаж ирүүлснээс санхүүжилт оройтсон байна. Тухайлбал,

- Хэнтий аймгийн Хэрлэн сумын халуун усны барилгын ажлын гэрээг 2006 оны 11 дүгээр сарын 12-нд хийсэн ба Сангийн яам 2006 оны 12 дугаар сарын 18-нд хүлээн авсан гэсэн акт, ажлын гүйцэтгэлийг үндэслэн 2006 оны 12 дугаар сарын 18-нд 13,0 сая, 2006 оны 12 дугаар сарын 28-д 1.0 сая төгрөгийн санхүүжилтийн эрх нээн санхүүжүүлсэн байна.
- Баянзүрх дүүргийн 111 дүгээр сургуулийн биеийн тамирын танхим барих ажлын гэрээг 2006 оны 11 дүгээр сарын 21-нд хийсэн ба Сангийн яам ажлын гүйцэтгэлийг үндэслэн 2006 оны 12 дугаар сарын 5-нд 29.0 сая, 2006 оны 12 дугаар сарын 19-нд 68.1 сая, нийт 97.1 сая төгрөгийн эрх нээж санхүүжүүлсэн байна.
- Ховд аймгийн Мөст сумын Усан цахилгаан станцын зураг төсвийн ажлын гэрээг 2006 оны 12 дугаар сарын 20-нд хийсэн ба Сангийн яам 2006 оны 12 дугаар сарын 25-нд хүлээн авсан актыг үндэслэн 2006 оны 12 дугаар сарын 25-нд 30.0 сая төгрөгийн санхүүжилтийн эрх нээж санхүүжүүлсэн байна.

2.8 Захиалагч, гүйцэтгэгч нарын хооронд ажлын уялдаа холбоогүй, гэрээний дагуу хариуцлага тооцож хяналт тавиагүйгээс нийт төсөл арга хэмжээний 29 буюу 16,6 хувь нь дуусаагүй, 4,6 хувь буюу 8 төсөл, арга хэмжээ огт хийгдээгүй байгаа ба нийслэл, аймгийн төрийн сангийн газраас хяналт хангалтгүй хийснээс Сангийн яамнаас 3235,4 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлийн хуурамч баримт (гүйцэтгэсэн ажлын тайлан, ажил хүлээн авсан акт, ЗД-ын тодорхойлолт)-аар авч гүйцэтгэгчид олгосон байна./Хавсралт А,Е /

2.9 Бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний батлагдсан төсвөөс Сангийн яаманд 149,0 сая, аймаг, нийслэлийн төрийн сангийн газарт 196,0 сая төгрөг тус тус зарцуулагдаагүй үлдсэн байна. Аудитаар 209,8 сая төгрөг зарцуулагдаагүй үлдсэнийг тогтоож, 211,6 сая төгрөгийн зөрчлийг арилгаж, 94,8 сая төгрөгийг төлүүлэх нь зүйтэй гэж үзсэн. /Хавсралт Д/

2.10 Аймаг, орон нутгийн төсөв, иргэд байгууллагын хандиваар 18 төсөл арга хэмжээнд 493,3 сая төгрөгийн нэмэлт хөрөнгө гаргасан байна. / Хавсралт А/

**II.2 Зарим төсөл, арга хэмжээг гэрээт хугацаанд хийгээгүй, шаардлага хангасан хөрөнгө нийлүүлээгүй байна**

2.11 Төсөл, арга хэмжээний 64,0 хувь гэрээнд заасан хугацаанд хэрэгжсэн бөгөөд 36,0 хувь санхүүжилт хугацаандаа ирээгүй, зориулалт, ажлын хэмжээ өөрчлөгдсөн, ажлын шинж чанараас шалтгаалж хүйтэнд хийж чадахгүй болсон, газрын асуудал шийдвэрлэгдээгүй, гүйцэтгэгч хариуцлага алдсан гэх мэт шалтгаанаар 3-270 хоног хоцорч хэрэгжсэн байна. Дуусаагүй ажлыг 2007 оны 6 дугаар сарын 1-ний байдлаар харуулбал: /Хавсралт Б,Е/

Бүсийн нэр	Төсөл, арга хэмжээний нийт тоо	Дуусаагүй төсөл, арга хэмжээ	Хийгдээгүй төсөл, арга хэмжээ	Гэрээт хугацаанд нь ашиглалтад өгөөгүй төсөл, арга хэмжээ
Төв	20	2	0	10
Баруун	30	4	1	9
Зүүн	21	6	3	11
Хангай	30	9	2	19
Улаанбаатар	73	7	2	13
Мэдээлэлжүүлэх төсөл	1	1	0	1
<b>Нийт дүн</b>	<b>175</b>	<b>29</b>	<b>8</b>	<b>63</b>


2.12 Хөрөнгө оруулалтаар Ховд аймгийн Хүүхдийн төлөө төв, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, Ерөнхий боловсролын сургуулиудад 83,0 сая төгрөгийн 18 нэр төрлийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хөрөнгийг 29 төсөвт байгууллагад тендергүйгээр бэлтгэсэн байна. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 22,1 сая төгрөгийн хөрөнгө материал бэлтгэн нийлүүлсэн “Авга ач нар” ХХК-ийн гэрээг албан ёсоор дүгнээгүй, анхан шатны баримт дутуу байна.

2.13 Орхон аймгийн Нэгдсэн эмнэлэгт “Бүрэнхайрхан” ХХК, “Моносфарм” ХХК, “Азиател” ХХК, “Эрдэнэс” ХХК –ийн нийлүүлсэн эмнэлгийн зарим багаж, төхөөрөмж нь хуучин ашиглагдаж байсан, техникийн үзүүлэлт хангалтгүй, хэрэгцээ шаардлагаас илүү хэмжээтэйгээр 15,6 сая төгрөгийн багаж тоног төхөөрөмжийг үр ашиггүй бэлтгэжээ. Тухайлбал,

- Худалдан авсан 2 ширхэг автоклав 1986, 1991 онд үйлдвэрлэгдсэн, урьд нь ашиглагдаж байсан, хуучин, монаметр ажиллагаагүй, мэс заслын хажуугийн гэрэл нь хүчин чадал муутайгаас мэс ажилбар хийх шаардлага хангахгүй байна. “Эрдэнэс” ХХК –ийн нийлүүлсэн 2 микроавтобус хөдөө орон нутагт явж эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээ хүргэх нөхцөл шаардлагыг хангахгүй байна.

2.14 Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх явцад нийт 2905,4 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэгдсэн бөгөөд үүнээс мэдээлэлжүүлэх төсөлд зарцуулсан 2099,6 сая төгрөгийг оруулалгүй тооцвол хөрөнгийн 58,3 хувь Улаанбаатарын бүсэд бэлтгэгдсэн байна. Гэвч зарим хөрөнгө, тоног төхөөрөмж зохих эзэндээ очоогүй, төлөвлөсөн зарим ажлууд хийгдээгүй, хийгдсэн ч чанар муутай байна.

Төсөл, арга хэмжээний үр дүнд бэлтгэн нийлүүлсэн хөрөнгө /сая.төг/




- “Нуган трейд” ХХК Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны өрхийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн тухай ажлын гүйцэтгэлийн актыг 2 удаа хийж, хянаж баталгаажуулсан боловч уг хөрөнгө зохих байгууллагад очоогүй байна.



2007.06.08-ны байдлаар Нуган трейд ХХК-ийн нийлүүлэхээр бэлтгэсэн 76.3 сая төгрөгийн 11 төрлийн тоног төхөөрөмж ЧД-ийн 18 дугаар хорооны агуулахад байна.

- “Дорнын Өргөө” ХХК –ийн СХД-ийн 1 дүгээр хороонд Спорт заал барих ажил хийгдээгүй, “Танан импекс” ХХК ЧД-ийн 14 дүгээр хороонд худаг гаргаагүй, түүнд зохицуулалт хийж, эмнэлгийн тоног төхөөрөмж бэлтгэсэн боловч зохих эмнэлэгт очоогүй байна.
- СБД-ийн 1,2 дугаар хорооны байрны дундах зам засварын ажлын гүйцэтгэгч “Бат зам” ХХК-ийн ажилтай танилцахад



СБД-ийн 1 дүгээр хорооны 220-н мянгатын 25, 26 дугаар байрын ар талын замын хашлага зам хоёрын хооронд асфальт дэвсээгүй, засварласан зогсоолын талбай цөмөрсөн байна.

СБД-ийн 2 дугаар хороо 3 дугаар байрын ар талын замд шороо асгаснаас өөр ажил хийгдээгүй байна.



СБД-ийн 2 дугаар хороо 29, 2б, 1а дугаар байрын дундах замын асфальтон хучилт нь дутуу хийгдсэнээс бэхжээгүй, хагарч бутарсан байна.

- СХД-ийн 1-6 дугаар хорооны цагдаагийн хэсэгт “Хурд интернэшнл” ХХК ОХУ-ын Иж Планета-5 мотоцикль нийлүүлсэн тухай ажлын гүйцэтгэлийн актыг Шадар сайдын ажлын албаны ажилтан С.Оюунцэцэг хянаж, УБ хотын ЗАА-ны инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн Ч.Ган-Очир захиалагчийн үүргийг гүйцэтгэж, СХД-ийн Засаг даргын орлогч Д.Ганболд, Тамгын газрын дарга П.Самдан нар хүлээн авч баталгаажуулсан ч БНХАУ-д үйлдвэрлэсэн мотоцикл нийлүүлсэн байна.



- Автодубай ХХК-иас СХД-ийн 4-6 дугаар хорооны өрхийн эмнэлэгт нийлүүлсэн хүрэн өнгийн Митсүбиши Эрвиэр маркийн комби машин, ногоон өнгийн Субару легаси маркийн комби, Ниссан плювер маркийн автомашинууд нь 5 хаалгатай, өвчтөнг хэвтүүлж тээвэрлэх боломжтой, стандарт, техникийн шаардлага бүрэн хангасан, техникийн үйлчилгээ, тохируулга бүрэн хийгдсэн, сэлбэг хэрэгслийн олдоц сайтай байх гэсэн гэрээний шаардлагуудыг бүрэн хангаагүй байна.

- “Эльком” ХХК –ийн ЧД-ийн 7-12 дугаар хороодод 2007 оны 2 дугаар сарын 19-нд нийлүүлсэн хог тээвэрлэх зориулалттай 4 авто машин гэрээний техникийн тодорхойлолтыг хангаагүй, шатахуун их зарцуулдаг, зарим машины очлуур эвдэрхий, урд тэнхлэг муу, нум ажилгүй, засч сэлбэх шаардлагатай бөгөөд одоогоор 4 авто машиныг ашиглаагүй, автомашины улсын үзлэгт оруулаагүй байна.



### ***II.3 Төсөл, арга хэмжээний үр дүнд бэлтгэсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй байна***

2.15 Бүс, нутгийн хөгжилд зориулж нийт 175 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж 7,255.1 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн боловч 64,6 хувь буюу 4686,7 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна. / Хавсралт В,Ж /

2.16 Данс бүртгэлд тусгаагүй хөрөнгийн 98,6 хувийг Улаанбаатар хотод хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ эзэлж байна. Нийслэлийн өмчийн харилцааны газар барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг нийслэлийн хөрөнгөд бүртгээгүй, Засаг даргын захирамжийг хэрэгжүүлээгүй байна. Нийслэлийн Санхүү эдийн засаг, төрийн сангийн хэлтэс санхүүжилтийг Улаанбаатар хотын орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн 2006 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгажээ. Иймд улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн, нийслэлийн өмчид бүртгэгдэх ёстой хөрөнгийг данс бүртгэлд тусгах шаардлагатай байна.

2.17 Аудитын явцад хийсэн судалгаанаас үзэхэд төсөл, арга хэмжээгээр бэлтгэгдсэн, засварлагдсан хөрөнгийн 85,7 хувийг зориулалтын дагуу ашиглаж, ажлыг бүрэн дуусгаагүй, чанаргүй хийгдсэнээс 14,3 хувийг ашиглаагүй байна. /Хавсралт В,З/

### ***II.4 Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг зохих журмын дагуу сонгоогүй байна***

2.18 Бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр нийт 175 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсаны 93,7 хувь буюу 163 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу сонгосон боловч Нийслэлийн ЗДТГ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 71 (давхардсан тоогоор) ажил хийгдсэний 30 ажилд тендер зарлаагүй байна. / Хавсралт Б/

2.19 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49-ийн 1-д “Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална” гэж заасны дагуу тендерийн материалыг Нийслэлийн ЗДТГ архивын нэгж болгоогүй байна.

2.20 Орон нутаг дахь төсөл, арга хэмжээний 57,2 хувийг Улаанбаатар хотын харъяаны, 42,8 хувийг тухайн аймгийн харъяалалтай аж ахуйн нэгж гүйцэтгэсэн байна. Анхны сонгосон гүйцэтгэгчийн 6,3 хувь нь ямар нэгэн шалтгаанаар солигдсон байна. / Хавсралт Б/

2.21 Булган аймгийн төвийн “С.Лхагвадорж баатрын талбай”-н засварын ажлын тендерт 5 компани оролцож “Булган барилга” ХХК шалгаран гэрээ хийгдсэн боловч явцын дунд гүйцэтгэгчийг сольж “Цонхот” ХХК болгосон байна. Гэвч СЯ болон Шадар сайдын ажлын албаны баримт материалд энэ ажлын гүйцэтгэгч “Булган барилга” компанитай гэрээ хийгдсэн материал байна.

2.22 Хөвсгөл аймгийн Түнэл сумын “80 хүүхдийн дотуур байрны засвар” –ын ажлын тендерт “Хөх-Тэнгэр Хөвсгөл” ХХК-ийг шалгаруулсан боловч аймгийн Засаг дарга Б.Батхүү тухайн компани нь сантехникийн мэргэжлийн инженер техникийн ажилтан байхгүй гэсэн шалтгаанаар “Цагаан-Уул Тэрхэн” ХХК-д уг ажлыг гүйцэтгэх эрх олгожээ.

2.23 Сүхбаатар аймгийн Дарьганга сумын 75 хүүхдийн цэцэрлэгийн барилгын гүйцэтгэгчээр шалгарсан Сүхбаатар аймгийн Шарга ХХК-ийг Улаанбаатар хотын Хадат мянган ХХК-аар сольж ажил үйлчилгээг гүйцэтгүүлсэн боловч ашиглалтад хугацаандаа өгөөгүй байна.

2.24 Архангай аймгийн Өлзийт сумын сургуулийн барилгын засварын ажлын гүйцэтгэгчийг тендер зарлалгүйгээр сургуулийн багш ажилчид өөрсдийн хүчээр хийж гүйцэтгэсэн байна.

2.25 Баян-Өлгий аймаг хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгчийг тендер зарлан сонгосон боловч Бугат сумын соёлын төвийн барилгын засварын ажлыг гүйцэтгэгч “Ашекей” ХХК 2006 оны 7 дугаар сарын 7-нд байгуулагдсан нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14 дүгээр зүйлд заасан нөхцөлийг хангаагүй, засварын ажлыг чанаргүй гүйцэтгэжээ.

2.26 Говьсүмбэр аймагт хөрөнгө оруулалтаар 28.3 сая төгрөгийн бараа, бүтээгдэхүүн нийлүүлсэн боловч тендер шалгаруулалт явуулалгүй Улаанбаатар хотын “ТТТ” ХХК-тай шууд гэрээ байгуулан ажилласан байна. Харин гүйцэтгэгч байгууллага нь гэрээний нөхцөлийг зөрчиж, барааг 14 хоногоор хоцроож нийлүүлсэн байхад гэрээний дагуу хариуцлага тооцоогүй байна.

2.27 Баянхонгор аймгийн ЗДТГ Баацагаан сумын соёлын төвийн засварын ажлыг гүйцэтгүүлэхээр “Рашаант” ХХК-тай тендер зарлалгүйгээр шууд гэрээ байгуулжээ.

### ***II.5 “Орон нутгийг мэдээлэлжүүлэх” төслийн ажил дуусаагүй, улсын комисс хүлээж аваагүй байна***

2.28 “Орон нутгийг мэдээлэлжүүлэх” төслөөр 21 аймгийн төв, Багануур, Зүүнхараа, Хархорин, Налайх зэрэг 4 хотыг 10 сувгийн, 306 сумын төв, Багахангай, Хялганат, Бор-Өндөр, Түнхэл, Хөтөл зэрэг 14 тосгоныг 4 сувгийн тоног төхөөрөмжөөр ханган олон сувгийн нэвтрүүлэг үзэх станцыг суурилуулан ашиглалтад оруулахад зориулж 2099,6 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

2.29 “Орон нутгийг мэдээлэлжүүлэх” төслийн телевизийн нэвтрүүлгийн олон сувгийн газрын сүлжээний 353 ширхэг иж бүрдэл, 1897,1 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээг 2006 оны 9 дүгээр сарын 1-нд Сансар кабель ХХК-тай хийсэн байна.

2.30 Дээрх тоног төхөөрөмжийг тээвэрлэх, суурилуулах, ашиглалтад оруулах ажлыг “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК, “Монголын цахилгаан холбоо” ХК гүйцэтгэхээр Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газартай гэрээ хийн 202,5 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

2.31 “Сансар кабель” ХХК гэрээнд зааснаар 2006 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр гэхэд сүүлчийн хэсгийг хүлээлгэн өгнө гэсэн боловч эхний хэсгийг 2006 оны 11 дүгээр сарын 25-нд, сүүлчийн хэсгийг 2007 оны 1 дүгээр сарын 10-нд, нийт 347 ширхэг иж бүрдэл тоног төхөөрөмж нийлүүлсэн байна. Гэрээгээр нийлүүлэх тоног төхөөрөмжөөс 6 ширхэг иж бүрдэл, нэмж нийлүүлэхээр тохиролцсон 8 иж бүрдлийг нийлүүлээгүйгээс станц суурилуулах ажил хийгдээгүй байна. Үүнд:

Суурин газрын нэр	Нийлүүлээгүй станцын тоо		
	Гэрээнд заасан	Нэмэлтээр өгөх	Станцын хүчин чадал
1.Төв аймгийн Алтанбулаг сум	1		ICTA-50
2. Дархан Уул аймгийн төв	1		ICTA-500
3. Орхон Уул аймгийн төв	1		ICTA-500
4. Сэлэнгэ аймгийн төв	1		ICTA-500
5. Өвөрхангай аймгийн төв	1		ICTA-500
6. Дорнод аймгийн төв	1		ICTA-500
7.Архангай аймгийн малчны хороо		1	ICTA-50
8. Баян Өлгий аймгийн Бугат сум		1	ICTA-50
9. Сэлэнгэ аймгийн Модны хороо		1	ICTA-50
10. Улаанбаатар Биокомбинат		1	ICTA-50
11.Улаанбаатар Налайх Городок		1	ICTA-50
12. Улаанбаатар Өлзийт хороо		1	ICTA-50
13. Улаанбаатар Шар хад		1	ICTA-50
14. Улаанбаатар Жаргалант хороо		1	ICTA-50
Нийт дүн	6	8	

2.32 “Сансар кабель” ХХК-ийн баталгаат хугацаанд дараахь аймагт суурилуулсан тоног төхөөрөмж ажиллахгүй байгаа ба түүнийг засварлах талаар ажил хийгээгүй байна.

Аймаг, сумын нэр	Нийлүүлэгдсэн станц	Засварт ирсэн хугацаа
1. Дундгов аймгийн Адаацаг	ICTA-50	2007.04.14
2. Ховд аймгийн Ховд хот	ICTA-200	2007.05.10
3. Багануур хот	ICTA-200	2007.06.06
4. Хэнтий аймгийн Бор Өндөр	ICTA-100	2007.05.14
5. Хэнтий аймгийн Өмнөдэлгэр	ICTA-50	2007.05.16
6. Хэнтий аймгийн Баян Адрага	ICTA-50	2007.06.10
7. Төв аймгийн Атар	ICTA-50	2007.06.07
8. Төв аймгийн Архуст	ICTA-50	2007.06.10
9. Орхон аймгийн Говил	ICTA-50	2007.04.25
10. Хөвсгөл аймгийн Бүрэн тогтох	ICTA-50	2007.06.11
11. Сэлэнгэ аймгийн Түшиг	ICTA-50	2007.06.11
дүн	11	

2.33 Станцууд болон дагалдах иж бүрдлүүдийг нийлүүлээгүй, засварлаагүйгээс ашиглалтад өгөх ажил удааширч ажлын болон улсын комисс хүлээн аваагүй бөгөөд суурилуулж дууссан аймаг, сум, сууринд тавигдсан тоног төхөөрөмжийн туршилт, жигдрүүлэлтийн ажил хийгдэж, орон нутагт ямар үнээр, ямар байгууллагын данс бүртгэлд авах шийдвэр гараагүй байгаа ба тээвэрлэх, суурилуулах, ашиглалтад оруулахтай холбогдсон зардалд 128,5 сая төгрөг зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна.



## Бүлэг 3

### Ажлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байжээ

#### **III.1 Орон нутгийн төр, захиргааны байгууллагаас хөрөнгийн зарцуулалт, ажлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байна**

3.1 Аудитын явцад хийсэн судалгааны дүнгээс үзэхэд нийт хэрэгжсэн төсөл, арга хэмжээний 25,1 хувьд ямар нэгэн хэмжээгээр хяналт шалгалт хийгдсэн, 74,9 хувьд хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.2 Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд орон нутгийн төр, захиргааны байгууллагаас тавих хяналт хангалтгүй байна. /Хавсралт В/

3.3 Тухайлбал: Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын 75 хүүхдийн цэцэрлэгийн барилгын чанар, Хатгал тосгонд ундны усны худаг гаргах ажлын үйл ажиллагаанд захиалагч болон мэргэжлийн байгууллагын зүгээс ямар ч хяналт тавьж ажиллаагүй байна.

3.4 Говьсүмбэр аймгийн Төрийн сангийн хэлтэс ажлын чиг үүргийн дагуу хяналт тавиагүй, “Цахим-Боржигин” мэдээллийн интернет төвд “ТТТ” ХХК-иас нийлүүлсэн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг зөвхөн тоо ширхэгээр хүлээн авсан, чанар, хүчин чадал, ашиглалтын талаар дүгнэлт гаргаагүй байна.

3.5 Нийслэлийн БХБТГ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний шинэ барилга, байгууламж барих 7 ажлыг хийхэд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн ч 1 ажил хийгдээгүй, 3 ажил дуусаагүй байхад ажлын гүйцэтгэлийн актыг урьдчилан хийж, баталгаажуулан эрхээ хэтрүүлсэн байна.

3.6 Нийслэлийн Засаг даргын 2006 оны 382 дугаар захирамжийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд орон нутгийн өмчлөгч, ашиглагч байгууллага хяналт тавих ажлыг зохион байгуулаагүй байна.

#### **III.2 Зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд орон нутгийн иргэдийн оролцоо хангалтгүй байжээ**

3.7 Аудитын явцад явуулсан санал асуулга, судалгаанд хамрагдсан иргэдийн 98,9 хувь төсөл, арга хэмжээг дэмжиж байгаа боловч төсөл, арга хэмжээний ажилд орон нутгийн иргэдийн оролцоо харилцан адилгүй байжээ. /хавсралт В/ Үүнд:

3.8 Говь-Алтай аймгийн хувьд гэрээ, хийгдэх ажлын жагсаалт, зураг төсвийг сум, сургуулийн удирдлагад өгөөгүй, тендер шалгаруулалтад оролцоогүй учраас орон нутгийн оролцоо бага байсан гэж сумын удирдлагууд үзэж байна.

3.9 Төв аймгийн сумдын ЗДТГ, соёлын төвүүдийн хувьд орон нутгийн оролцоо хангалттай байсан гэж үзэж байгаа бол, цагдаагийн хэсгүүдийн барилгын их засвар, машин тоног төхөөрөмж худалдан авахад орон нутаг, сумын оролцоо дунд зэрэг гэж судалгаанд оролцогчид үнэлжээ.

3.10 Сүхбаатар аймгийн Үйлдвэрлэл, дэд бүтэц, байгаль орчны бодлого зохицуулалтын хэлтэс, Барилга хот байгуулалтын алба, Төрийн сангийн хэлтсийн ажлын уялдаа холбоо хангалтгүй, төсвийн хөрөнгийн зарцуулалт, ажлын явц, гүйцэтгэлийн чанарт тавих хяналт суларч, хөрөнгө оруулалтаар баригдах болон засварлах барилга объектуудын санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллагад ажлын гүйцэтгэлийг харгалзалгүй шууд шилжүүлснээс ажил үйлчилгээг гэрээний дагуу цаг хугацаанд нь хийхгүй, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд аймгийн удирдлагууд чанарын хяналтыг орхигдуулж, анхаарал тавиагүй байна.

3.11 Хэнтий аймгийн Бэрх тосгоны цэцэрлэгийн барилгын ажлаас бусад хөрөнгө оруулалтын ажилд аймаг, орон нутгийн оролцоо үндсэндээ байсангүй.

3.12 Ховд аймгийн иргэд Манхан сумаас Мөст сум хүртэл өндөр хүчдэлийн шугам сүлжээ барихаар шийдвэрлэсэн тул УЦС барих шаардлагагүй гэж дүгнэж байна.

## Дүгнэлт

Аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт гаргаж байна. Үүнд:

1. Аудитын явцад хийсэн судалгаанаас үзэхэд нийт төсөл, арга хэмжээний 96,6 хувийг тухайн аймаг, сумын сонгогчид болон орон нутгийн төр, захиргааны байгууллагуудаас УИХ-ын гишүүдэд тавьсан санал, хүсэлтийг үндэслэж, аймаг, сумын төрийн захиргааны байгууллагуудын ажилтай уялдуулж төлөвлөсөн байна.
2. Гэвч зарим төсөл, арга хэмжээ орон нутгийн ажилтай уялдаагүй, тэргүүлэх ач холбогдлыг харгалзан үзээгүй, хэрэгжих боломжгүй, үр дүн муутай болжээ. Энэ нь төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, санхүүжилт хугацаа алдсан, төсөл, арга хэмжээний жагсаалтад зохицуулалт, өөрчлөлт хийгдсэн, хяналт суларсан зэргээс шалтгаалжээ.
3. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуульд заасны дагуу тендер зарлахгүй гүйцэтгэгчийг сонгосон нь төсөл, арга хэмжээний ажил чанаргүй болоход нөлөөлсөн байна.
4. “Орон нутгийг мэдээлэлжүүлэх” төслийн ажлыг төлөвлөхдөө шаардагдах тоног төхөөрөмжийн хүчин чадлыг алдаж тооцсоноос гүйцэтгэлээр өөр хүчин чадалтай тоног төхөөрөмж угсарч төсөвт өртөг нэмэгдэж, улмаар нэмэлт хөрөнгөгүйгээр төслийн ажлыг дуусгаж чадахгүйд хүрчээ. Төслийн ажлыг дуусгаагүйгээс улсын комисс хүлээж аваагүй, эвдэрсэн тоног төхөөрөмжийг засварлаагүй хугацаа алдсан байна.
5. Нийт санхүүжилтийн ихэнхийг оны эцэс рүү хийсэн, захиалагчийн хяналт хангалтгүй байсан зэргээс шалтгаалан тайлант онд 29 төсөл арга хэмжээ дуусаагүй, 8 төсөл, арга хэмжээ хийгдээгүй ба 2006 оны эцэст аймаг, нийслэлийн төрийн сангийн газарт 196,0 сая төгрөгийн санхүүжүүлээгүй үлдэгдэлтэй байна.
6. Бүс, орон нутгийн хөгжилд зориулж улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтад орон нутгийн төр, захиргааны байгууллагаас тавих хяналт сул байснаас илүү санхүүжилт олгосон, гүйцэтгэлийн баримтыг хуурамчаар үйлдэж санхүүжилт авсан, барилгын ажлыг чанаргүй хийсэн, шаардлага хангасан машин, тоног төхөөрөмж нийлүүлээгүй, хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгахгүй орхигдуулсан зэрэг зөрчил илэрлээ.

## Холбогдох байгууллагын Санал



### МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: 26-02-47, <http://www.mof.gov.mn>

2007.11.14 № 79/5239  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОР Л.ЖАВЗМАА ТАНАА

Санал хүргүүлэх тухай

“Бүс орон нутгийн хөгжилд зориулж олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүн, орон нутгийн оролцоо”-д хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Гарсан санал дүгнэлт, зөвлөмжид дараах тайлбар, саналыг өгч байна. Үүнд:


1. УИХ-ын гишүүдийн 100,0 сая нийт 7,6 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхдээ тухайн аймгийн Засаг дарга, гүйцэтгэгч байгууллагатай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээ, аймгийн захиалагч болон ерөнхий захиалагчийн хянаж ирүүлсэн гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилтийн эрхийг нээж, санхүүжилтийг Ерөнхий захиалагч болох Шадар сайдын ажлын албаны дансанд шилжүүлж байсан. Гишүүдийн хэт жижиглэсэн 200 гаруй гэрээ, гүйцэтгэлийг хүлээн авч хянан санхүүжүүлэхэд хүндрэлтэй байсан ч ирсэн гүйцэтгэлийг 1-2 хоногт багтаан хянаж, санхүүжилтийн эрхийг нээж байсан бөгөөд гүйцэтгэгчээс ямар нэгэн гомдол, санал ирж байгаагүй. Мөн түүнчлэн барилга объектыг ашиглалтад хүлээн авсан комиссын актыг үндэслэн эцсийн санхүүжилтийг хийдэг байсан бөгөөд зарим ашиглалтад ороогүй барилгын хөрөнгийг олгоогүй. Төслийн Е хавсралтад дурдсан объектуудыг санхүүжүүлээгүй шалтгаан нь Сангийн сайдын 2006 оны 395 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвөөс хөрөнгө оруулалт, их засвар, тоног төхөөрөмжийг санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын 2.4-ийн “е” заалтад барилга объектыг ашиглалтад хүлээн авсан тухай ажлын болон улсын комиссын актыг үндэслэн сүүлчийн санхүүжилтийг хийхээр заасан байдаг тул акт ирээгүй барилга байгууламж, төслийн сүүлийн санхүүжилтийг олгоогүй болно. Үүнээс үүсэх хариуцлагыг захиалагч гүйцэтгэгч нар хариуцах журамтай.
2. Төслийн 2-р бүлгийн 2.2 дугаар заалтад дурдсан гүйцэтгэгчид шууд олгосны шалтгаан нь оны эхэнд Шадар сайдын ажлын алба төрийн сангийн дансаа нээлгээгүй байсан, мөн Хэнтий аймгийн Өндөрхаан сумын Нэгдсэн эмнэлэгийн сэхээн амьдруулах тасагт олгосон 14,2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг УИХ гишүүн өөрөө тухайн үед нь хүлээлгэн өгөх болсонтой холбоотой юм.
3. Нийт санхүүжилтийн ихэнх нь оны эцэст гарсан нь захиалагч орон сууцны дээврийн болон зам засварын ажлын тендерийг оны эцэст зарласан, тоног төхөөрөмж худалдан авах гэрээнүүд 12 сард ирсэн бөгөөд УИХ-ын гишүүд батлагдсан хөрөнгийг өөр барилга, арга хэмжээнд олон удаа шилжүүлсэн, зохицуулсан зэргээс шалтгаалсан юм. Түүнчлэн аймгийн ЗДТГ гэрээ, гүйцэтгэлийн материалыг ихэвчлэн оны эцэс рүү ирүүлсэн бөгөөд харин тус яамнаас ирсэн гүйцэтгэлийг журмын дагуу 1-2 хоногт багтаан хянаж, санхүүжилтийн эрхийг нээж байсан.
4. Сангийн сайдын 2006 оны 11 сарын 29 өдрийн 395 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвөөс хөрөнгө оруулалт, их засвар, тоног төхөөрөмжийг санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4 дүгээр заалтад Улсын төсвийн хөрөнгийг зориулалт бусаар үр ашиггүй зарцуулсан, барилгын ажлын

08 4980

гүйцэтгэлийг буруу гаргасан хариуцлагыг тухайн Төсвийн ерөнхийлөн захирагч, газрууд шууд хариуцна гэж заасан байдаг. Гүйцэтгэл буруу гарсан, ажил чанаргүй хийсэн, хяналт муу тавьсан хариуцлагыг захиалагч, аймгийн удирдлага хариуцах ёстой. Учир нь санхүүжилтийг шууд гүйцэтгэгчид олгоогүй, газар дээр нь хяналтыг тавиулж, барилга объектыг цаг хугацаанд нь чанар сайтай ашиглалтад оруулахын тулд аймгийн Засаг даргатай гэрээг байгуулан, хөрөнгийг нь аймгийн төрийн санд шилжүүлж байсан.

5. Зөвлөмжийн төсөлд Сангийн сайд Н.Баяртсайханд “Хууль зөрчиж ажлын гүйцэтгэгч сонгосон, хуурамч баримт үйлдэн санхүүжилт авсан байгууллага, хүмүүст хариуцлага тооцох” гэсэн заалтыг захиалагч шууд хариуцлага тооцох, шүүхэд шилжүүлэх хариуцлагыг гэрээгээр хүлээсэн байдаг тул Ерөнхий захиалагчид буюу Шадар сайдад зөвлөмж болгох нь зүйтэй гэж үзэж байна.
